

АЖЛЫН ХУУДАС

СЭДЭВ. *Параметртэй квадрат тэгшитгэл*

1. k -ийн ямар утганд $5x^2 - kx + 5 = 0$ тэгшитгэл хоёр шийдтэй байх вэ? Зөв хариултыг сонгоорой.
A. $-10 < k < 10$ B. $k < -10, k > 10$ C. $k < -10$ D. $k > 10$
2. $x^2 - (m - 1)x + m + 1 = 0$ тэгшитгэлийн язгуурууд x_1 ба x_2 нь $x_1^2 + x_2^2 = -4$ нөхцлийг хангадаг байх m - ийн бүх утгыг олоорой.
a. -1 b. 1 c. 4 d. 3 e. 5
3. $f(x) = mx^2 - 4x + m - 3$ парабол Ox тэнхлэгийг шүргэдэг байх m - ийн утгыг сонгоно уу. $m = ?$
4. $25x^2 + 20x + a = 0$ ганц язгууртай байх a -ийн утгыг бичнэ үү. $a = \dots\dots$
5. $f(x) = mx^2 - 2mx + m + 1$ функцийн график нь Ox тэнхлэгтэй огтлолцохгүй байх m - ийн утгыг олоорой.
A. $m < 4$ B. $m > 0$ C. $m > 4$ D. $m < 0$
6. $x^2 + (k^2 - 2k)x + 24 = 0$ тэгшитгэлийн язгууруудын нийлбэр 63 байх k - ийн утгуудыг ол.
a. 5 b. -2 c. -9 d. -7 e. 9 f. 7
7. $y = 2x^2 - 3x + k$ функц нь $B(1; -2)$ цэгийг дайрдаг байх k – ийн утгыг бичнэ үү. $k = \dots\dots\dots$
8. $f(x) = mx^2 + (m - 1)x + 3$ параболын оройн цэг Oy тэнхлэг дээр байх бол m –ийн зөв утгыг сонгоно уу. $m = ?$
9. $x^2 + (m + 1)x - 3 = 0$ ба $x^2 + 2mx - m = 0$ тэгшитгэлийн шийдүүд ижил бол m -ийн утгыг сонгоно уу.
A. 5 B. 3 C. 1 D. -1
10. $x^2 - (m - 3)x - 8 = 0$ тэгшитгэлийн шийдүүдийн хувьд $x_1 = x_2^2$ нөхцөл биелдэг бол m – ийн утгыг олно уу. $m = ?$

Амжилт хүсье.

